



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ  
ТЭМДЭГЛЭЛ**

2025 оны 03 сарын 10 өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн хуралдааны тэмдэглэл:


**ХЭЛЭЛЦСЭН нь:**

“Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр”-ийн төслийг зөвшилцөх.

**ШИЙДВЭРЛЭСЭН нь:**

“Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр”-ийн төслийг зөвшөөрч, гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгов.

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД  
БОДЛОГЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА



Г.ТЭМҮҮЛЭН

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД  
БОДЛОГЫН БАЙНГЫН  
ХОРОО ХАРИУЦСАН РЕФЕРЕНТ

*Б.Гандиймаа*

Б.ГАНДИЙМАА

**“ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ МОНГОЛ  
УЛС БОЛОН БҮГД НАЙРАМДАХ ЧЕХ УЛС ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР”-ИЙН  
ТӨСЛИЙГ ЗӨВШИЛЦСӨН ТАЛААРХ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2025 оны 03 дугаар  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот


Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдөр Улсын Их Хуралд зөвшилцөхөөр ирүүлсэн “Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр”-ийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 75 дугаар зүйлийг үндэслэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хэлэлцээрийн төслийг Хууль зүйн байнгын хороо урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлтээ ирүүлснийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанаар нэгтгэн хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлээгүй болно.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх “Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр”-ийн төслийг зөвшөөрч, гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгов.

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД  
БОДЛОГЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА**



**Г.ТЭМҮҮЛЭН**